



ОРОН НУТГИЙН МЭДЭЭЛЭЛ

2020.09.24

Даланзадгад

Өмнөговь аймгийн 2020 оны 09 дүгээр сарын мэдээ

Нэг. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаархи мэдээлэл

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА:

Гадаад харилцаа дотоод ажил

Гадаад харилцааны чиглэлээр:

- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур хоттой 3 удаа холбогдож Цагаан хад гаалийн хяналтын талбай суурьшлын бүсэд хийгдэх ЦДАШ-ын айлын талаас шалтгаалах ажлын явцын талаар мэдээлэл, ӨМӨЗО-ны Альшаа аймгийн Засгийн ордны Г адаад харилцааны албанаас ирүүлсэн мах импортлох талаархи хүсэлтийг хүлээн авч удирдлагууд болон холбогдох мэргэжлийн байгууллага болон албан хаагчид хүргүүлж ажилласан.
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх судалгаа мэдээллийн хүрээлэн рүү нутгийн захиргааны бүх байгууллагуудын бүтэц орон тоо болон 15 сумын ерөнхий мэдээллийг авч, нэгтгэж хүргүүлэв.
- Дэд хөтөлбөрийн 4 жилийн тайлан, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих 2 арга хэмжээний төслийг боловсруулж байна.

Дотоод ажлын чиглэлээр:

- Байгууллагын албан хаагчдын өдөр тутмын ирц бүртгэлийг хурууний хээн бүртгэлээс и оффис програмд татаж оруулсан.
- Байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой 3 тушаалын төсөл боловсруулж, 3 албан хаагчийн өргөдлийг уламжлан шийдвэрлүүлж, ээлжийн амралт эдэлсэн байдлыг тооцож нэгтгэн байгууллагын удирдлагад танилцуулав.
- Хүний нөөцийн нэгдсэн программд 3 албан хаагчийн мэдээллийг нэмж тодотгов.
- Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 4 баримт бичгийн хавтсыг цэгцэлж, албан хаагчдын улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хэрэгжилтийг архивласан.

Хүний нөөцийн асуудал, төрийн албаны салбар зөвлөл

- Удирдлагын академиас Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан богино хугацааны сургалтуудыг танхимаар болон танхимын бус хосолсон хэлбэрээр зохион байгуулагдаж эхэлсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолд “Төрийн албанд анх томилогдсон иргэнийг төрийн албаны онцлог, үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээ, эрх зүйн болон төрийн албаны стандарт, шаардлагад нийцэн ажиллах мэдлэг чадвар эзэмшүүлэх зорилго бүхий 40 цагийн чиглүүлэх сургалтад заавал хамруулна” гэж заасны дагуу чиглүүлэх сургалтад аймаг, сумаас нийт 9

төрийн албан 9 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлүүлэн зайны сургалтад хамрагдаж байна.

- Мөн 9 дүгээр сарын 19 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд "Төрийн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ" сэдэвт ажлын байран дахь сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газар болон харъяа агентлагийн төрийн албан хаагчид нийт 35 хүн оролцож 16 цагийн хичээл судалсан байна. Удирдлагын академийн захирлын тушаалаар сургалтад идэвхтэй оролцсон 35 төрийн албан хаагчдад сертификат олголоо.
- Төрийн албаны нөөц бүрдүүлэх зорилготой 2020 оны төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулах асуудлыг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж товыг тогтоож, олон нийтэд мэдээлж байна. Үүнтэй холбогдуулан сум, байгууллагуудын дарга эрхлэгч нарт албан тоотоор чиглэл хүргүүлэн ажиллав.

Нутгийн захиргааны байгууллага, өргөдөл гомдол:

9 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 529 өргөдөл гомдол ирснээс бичгээр 495, цахимаар 32, биечлэн-2 ирсэн байна.

Хугацаанд нь шийдвэрлэсэн өргөдөл гомдол-456, хугацаандаа яваа-44, шийдвэрлээгүй хугацаа хэтэрсэн-9, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 20 өргөдөл байна.

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар хэлтэс байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хяналт тавьж, сар улирлын шуурхай бүрт танилцуулга, мэдээлэл хийж, шийдвэрлэлтийг хянах, иргэдэд шуурхай мэдээлэлх тал дээр анхаарч ажиллахыг зөвлөж ажиллаж байна.

Нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүдийн шуурхай хурлыг энэ сарын 9-ний өдөр зохион байгуулж, Засаг даргын дэргэдэх 22 агентлаг, 16 сургууль цэцэрлэг, 9 төсөвт байгууллага аж ахуйн нэгжүүдийн дарга, удирдлага, эрхлэгч нарт аймгийн удирдлагууд төв суурингийн өвөлжилтийн бэлтгэлийг чанартай хангах, мал малчдад туслах аян өрнүүлэх, албан хаагчдын ажлыг эрчимжүүлэх хариуцлагыг өндөржүүлэх зэрэг чиглэлээр мэдээлэл хурлыг хийсэн байна.

Сум, орон нутаг

ДАЛАНЗАДГАД

нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2019, 2020 онд хийгдсэн ажлуудад "Иргэний нийгмийн байгууллагын сүлжээ зохицуулагч" байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллахаар удирдамж боловсруулан ажиллаж байна.

Засаг даргын А захирамж 21, Б захирамж-2, Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал-13, Б тушаал-6

2020 оны 08 сард Даланзадгад сумын ЗДТГазарт 125 албан бичиг хүлээн авснаас 19 бичиг нь хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэж. Засаг дарга болон Тамгын газраас 48 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлж ажилласан.

Ирсэн санал, өргөдөл гомдол 57, шийдвэрлэж хаасан 39, Хугацаандаа яваа 18

"Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний тухай" Өмнөговь аймгийн Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 05 тоот албан даалгавар. Мал аж ахуй эрхэлж байгаа иргэд, малчдыг мал сүргийн хамт 2020-2021 оны өвөлжилтийг өнөтэй, хохирол багатай даван туулах, мал өвөлжилт, хаваржилтын ажлыг эртнээс зохион байгуулах, үүсч болзошгүй цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга, ХХААГазар, Мал эмнэлгийн газар, БОЭТөв, УЦУОШТөв, Онцгой байдлын

газар, Малчид, мал бүхий иргэд, Аймаг, сумын төвийн албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд нийт 53 заалт бүхий албан даалгаварын баг мэргэжилтнүүдэд хүргүүлж хэрэгжилтийг 10 дугаар сарын 25-ны дотор гарган ажиллахыг даалгалаа.

“Өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний тухай” Даланзадгад сумын Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 01 тоот албан даалгавар. 2020-2021 оны өвөлжилтийг өнөтэй, хохирол багатай даван туулах, мал өвөлжилт, хаваржилтын ажлыг эртнээс зохион байгуулах, үүсч болзошгүй цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор багийн Засаг дарга нар, малчин, мал бүхий иргэдэд нийт 8 заалт бүхий албан даалгавар гаргаж, хэрэгжилтийг сар бүрийн 10-нд Хөдөө аж ахуйн тасагт хүргүүлж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгалаа.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал

2020.08.20-23-ны өдрүүдэд Хангайн бүс болон Говийн бүсийн төвийн сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг хамруулсан “Харилцан туршлага солилцох” сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж 200 гаруй төрийн албан хаагчид хамрагдлаа. 2020.08.15-20-ны өдрүүдэд Цэцэрлэг, сургуулийн шинэ хичээлийн жил өндөржүүлсэн бэлэн байдлын үед эхэлж байгаатай холбогдуулан Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран сургууль, цэцэрлэгийн бэлтгэл ажилтай танилцан холбогдох үүрэг чиглэл өгч ажиллаа.

2020.08.27-нд Даланзадгад сумын нийтийн орон сууцны гаднах нийтийн эзэмшлийн талбайн тохижилтын ажлын явцтай Даланзадгад сумын ИТХ-н дарга Т.Мэндээ холбогдох мэргэжилтнүүдийн хамт барилгын талбай дээр хяналт тавьж ажиллаа. Хяналт тавих үеэр гүйцэтгэгч байгууллага болох Шинэ мөнх дөл ХХК-н удирдлагуудад чанартай ажиллах, түргэн шуурхай зохион байгуулалттай ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг өдөр тутамд мөрдөж ажиллах үүрэг чиглэлийг өгч ажиллаа.

2020.09.07-нд Даланзадгад сумын Засаг дарга "Боловсролын салбарыг дэмжих жил"-ийн хүрээнд Америк улсын “Холт интернейшнл” төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзаж цэцэрлэгийн хүүхдийн нэмэлт хоол тэжээл, зорилтод бүлгийн хүүхдийн суралцах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн талаар санал бодлоо солилцлоо. Тус хөтөлбөрүүдэд Даланзадгад сумаас 105 хүүхэд хамрагдаж байна.

2020 оны 09 дүгээр сарын 18-нд Дундговь аймагт зохион байгуулагдсан “Бэлчээрийн доройтлыг бууруулж менежментийг сайжруулах, малын гаралтай бүтээгдэхүүний гадаад зах зээлийг нэмэгдүүлэх нь” сэдэвт говийн бүсийн аймгуудын (Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Төв, Баянхонгор) нэгдсэн сургалтад мэргэжилтэн С.Баярмаа, Ч.Дүүрэнжаргал нар хамрагдлаа.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Даланзадгад хот байгуулагдсаны 55 жилийн түүхт дурсамжит номны сонгон шалгаруулалтад шалгарсан Ингэмэл ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгэлийн шатандаа явж байна.

Соёл амралтын хүрээлэнгийн гадна, дотор талыг хэсэгчлэн засварлах, Стандартын тамхины цэг байгуулах ажлыг Даянбайгаль ХХК-н, Төвийн гадна гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийг нэмэгдүүлэх Багц-2 ажлыг Хануй-Энержи ХХК, 3 сургуулийн биеийн тамирын талбайг тохижуулах ажлыг Девсофт ХХК, Хонгор овоо чиглэлд 0,4 квт-н ЦДАШ-н өргөтгөлийн ажлыг Батаарын жигүүр групп ХХК тус тус хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан.

Гэр хорооллын орчин нөхцөлийг сайжруулах ажлын гэрээг Дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна.

Даланзадгад сумын Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн А/179 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдөр хуралдаж хөдөө аж ахуй, мал эмнэлэг, багийн Засаг дарга нар гэсэн 3 чиглэлээр нийт 22 заалт бүхий “Даланзадгад хотын 2020-2021 оны өвөлжилт,

хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө”-г хэлэлцэн баталж. Үр дүнг 10 дугаар сарын 20-ны дотор нэгтгэн дүгнэж ХХААГазарт хүргүүлэн ажиллахыг Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасаг, багийн Засаг дарга нар т даалгалаа.

“Өрх гэр бүлийг дэмжих жил”-ийн хүрээнд орон сууцны байшин барьж өгөх тэтгэлэгт 8 багаас тус бүр 1 өрхийг хамруулж ажлын гүйцэтгэл 96 хувьтай явагдаж байна.

Даланзадгад сумын 2020 оны төсвийн орлогын төлөвлөгөө 3745340,0 мян.төгрөг гүйцэтгэл 1988931,7 мян.төгрөг болж 53,1 хувь биелсэн, өөрийн орлогын төлөвлөгөө 6666,8 мян.төгрөг, гүйцэтгэл 6941,5 мян.төгрөг 104,1 хувьтай байна.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил, арга хэмжээ:

2020-2021 оны хичээлийн жилийн нээлтийг тохиолдуулан Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газраас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар харьяа 6 сургуулийн түшиц кабинетууд, 10 цэцэрлэгт нэн шаардлагатай байгаа 53 нэр төрлийн 75 ширхэг сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг гардуулан өглөө.

“Эрүүл бие – Амжилтын үндэс” төслийг хэрэгжүүлж Улсын Тэргүүний 1 дүгээр сургууль, Улсын Тэргүүний 2 дугаар сургууль, Улсын Тэргүүний 3 дугаар сургууль, 4 дүгээр сургууль, 5 дугаар сургууль, Биеийн тамир спортын төрөлжсөн сургалттай 7 дугаар сургууль, 1, 2, 4, 8, 9, 11, 23, Улсын Тэргүүний 24 дүгээр цэцэрлэг, 25, 26 дугаар цэцэрлэгийн эмчийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулан 10 нэр төрлийн 533 ширхэг багаж хэрэгслийг гардуулан өглөө. Уг төсөл хэрэгжсэнээр суралцагчдын ая тухтай орчин нөхцөлд суралцах эрүүл мэндийн тусламж хүргэх, өөрсдийн эрүүл мэндээ хянах боломжийг бүрдүүлж, эрүүл ахуй, зөв дадал хэвшлийг бий болгон тэдний эрүүл мэндийг хамгаалахад оршино.

Чөлөөлөх дайны түүхт ялалтын 75 жилийн ойн өдрөөр Даланзадгад сум/хот/-ын ИТХ, ЗДТГ, Далан 3 дугаар баг хамтран Баруун хилийн тулгаралтад оролцож явсан ахмад дайчин, эдүгээ 100 настай ахмад С.Яринпэлд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан .

Даланзадгад сумаас гарсан мал эмнэлгийн 105 гарал үүслийн гэрчилгээнд баталгаажуулалт хийгдсэн.

8 багийн мал бүхий иргэдийн мал угаалга, хашаа хорооны ариутгалын ажил 220 өрхийн 224 хашаа хорооны 100800м² талбай, 229 өрхийн 133,4 бог малыг угаасан байна.

Тав. Багт зохион байгуулагдсан ажлууд

Их-Уул 6-р багийн Нисэх хорооллын гэрэлтүүлгийн ажлыг Хануй-Энержи ХХК хийж гүйцэтгэн байнгын ашиглалтад оруулсан.

Далан 3 дугаар багийн 15, 39-р байрны гадна засвар, Цагаан булаг 8 дугаар багийн Арслан хотхон, Барилгачдын орон сууц, Их-Уул 6 дугаар багийн 4-р орон сууцны гадна нийтийн эзэмшлийн талбайн тохижилтын ажлыг хийгдсэн. Зүүнсайхан 5 дугаар багийн Хонгор-Овоо чиглэлд 0,4 квт-н ЦДАШ хийгдсэн.

2020.08.28-08.30 Багийн нутаг дэвсгэрт нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулан 10 тн хогийг хогийн цэгт төвлөрүүлсэн.

НҮБ-ын “Хүүхдийн сан”-аас санаачлан хэрэгжүүлж буй өрхөд зориулсан эрчим хүчний хэмнэлттэй халаалт, дулаалгын багцад 8 багийн туршилтын 16 өрхийг хамруулаад байна.

2020.09.13-нд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Бүх хайраа гэр бүлдээ” чуулганд 8 багийн 40 гэр бүл оролцлоо.

20.09.15-17-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Насан туршийн боловсролын төв, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол соёл урлагийн газраас хамтран зохион байгуулсан, “Угийн бичгийг түгээн дэлгэрүүлэх, угийн бичиг хөтлөлт”-ийн талаар туршлага солилцох үзэсгэлэнгийн арга хэмжээнд 8 багаас 18 өрх оролцлоо.

УИХ-ын гишүүн Н.Наранбаатарын уулзалтад 8 багийн 400 гаруй иргэн оролцлоо.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зарласан “залуучуудын сарын аян”-ны хүрээнд 1-р баг, 6-р багууд багийн төвдөө залуучуудын танхим тохижуулж,нээлт хийх арга хэмжээнд тус бүр 60 гаруй иргэн оролцсон байна.

2-р баг, 8-р багууд багийн залуучуудын зөвлөлийг шинэчлэн байгуулсан.

7-р баг багийн номын сан байгуулж охижууллаа.

МАНЛАЙ

Нэг : Сумын Засаг даргын Захирамж , Тушаал:

Нийт А захирамж – 2, Б захирамж-1, Б тушаал –8 тус тус гарсан байна. .

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

Говийн Оюу хөгжлийг дэмжих санд төсөл бичиж хэрэгжүүлсэн 14 иргэнд тус сангаас “Мэдээллийн ач холбогдол” сэдэвт сургалт зохион байгуулсан.

Жил бүрийн 9 дүгээр сарын 10-нд тохиодог “Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр”-т зориулан 9 дүгээр ангийн 20 сурагчид “Хэлмэгдэгсэд ба тэднийг цагаатгахын учир” сэдэвт хичээл бэлтгэн хүргэж, төгсгөлд нь сурагчдын бусдыгаа үнэлэх, өөрийгөө үнэлэх, өөртөө итгэлтэй урам зоригтой суралцахад чиглэсэн 15 минутын хичээл, оюуны тоглоом тоглуулах ажил зохион байгууллаа

7-9 дүгээр ангийн 21 сурагчийг “Мини парламент”-ийн төлөөлөгчөөр элсүүлэн, анхдугаар чуулганаа зохион байгуулахаар бэлтгэж байна.

Дундговь аймагт болсон Бэлчээрийн доройтлыг бууруулж, менежментийг сайжруулах бүсийн сургалтад ХАА Малын үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн хамрагдсан.

2020.08.26-29ны хооронд цэцэрлэгийн Эрхлэгч, тогооч, хөгжмийн багш, ЗАН-ын ахлагч Өмнөговь аймагт Онцгой нөхцөлийн үед хичээл сургалт явуулах зөвлөгөө зөвлөмжийн сургалтад хамрагдсан.

2020 оны 09 дүгээр сарын 04, 05-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Даланзадгад хотноо Монгол ВИ.и.Ти.нет төрийн бус байгууллага малын эмч нарын хамрууллаа

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 4-дүгээр улирлын ажлын төлөвлөгөөг гарган батлуулсан. 4–дүгээр улиралд 8 ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас 2016-2020 онд хуралдсан Төлөөлөгчдийн болон Тэргүүлэгчдийн хурлын тоо, хэлэлцсэн асуудал, гарсан тогтоол шийдвэрийн тоон судалгааг гаргаж 21 төлөөлөгчиддөө мэдээлэл хүргэв. 2016-2020 оны хугацаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид 10 удаа хуралдаж, 91 асуудал хэлэлцэн 89 тогтоол гаргасан бол, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 36 удаа хуралдаж, 137 асуудал хэлэлцэн, 142 тогтоол шийдвэрүүдийг тус тус гаргажээ.

ЗДТГ /Дотоод ажил, хууль эрх зүй/ :

Говийн оюу ХДС-ийн зорилтот суманд олгогддог санхүүжилтийн квотын хүрээнд хэрэгжсэн 2 төслийн гүйцэтгэлд хяналт тавьж ,ажлыг хүлээн авч холбогдох тайлан мэдээнүүдийг хүргүүлсэн.

Өрх гэр бүлийн жилийн хүрээнд зорилтот 1 өрхөд орон сууцны байшин барьж хүлээлгэн өгсөн.

ХШҮДАХ-ын №13, 14, 15 тоот зөвлөмжүүдийг и-оффис програмд хяналтад авч холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулж эзэнжүүлсэн.

15-р цэцэрлэгийн 25 албан хаагчдад байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах тайлагнах талаар сургалт зохион байгуулж чиг үүрэг зөвлөмжийг өгсөн.

Бүх хайраа гэр бүлдээ онлайн чуулга уулзалтад хамрагдсан.

Ёс зүйн хорооны цахим хуралд 21 албан хаагч хамрагдсан.

Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн удирдлагын академийн төрийн албаны онлайн хичээлд сурч байна.

Сумын төвийн засмал замын ажил явган хүний болон дугуйн замаа хийж 80% гүйцэтгэлтэй явагдаж байна.

Сумын төвийн нийтийн эзэмшлийн талбай ашиглалтад орж хүүхэд залуучууд чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлж байна. хур системийн Операторын тоног

төхөөрөмж ашиглалтад оруулж хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн хариуцсан ажиллаж нийт 7 лавлагаа тодорхойлолт гаргасан .

Авилгын эсрэг үндэсний хөтөлбөрийг сурталчлах хүрээнд авилгын эсрэг 5 төрлийн видео шторкуудыг цахимаар иргэд олон нийтэд танилцуулж 652 хүн үзсэн хандалттай байна.

8-р сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлангаа гаргаж батлуулсан.

Сумын ХШҮ-ний нэгжийн 2-228 тоот зөвлөмжийг төсөвт 3 байгууллагад хүргүүлж хэрэгжилтийг хүлээн авсан.

Мал эмнэлэгийн тасаг:

Аймгийн засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/245 тоот захирамж, 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/89 тоот сумын засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын хэмжээнд хонь-82767, ямаа-123635, үхэр-91, нийт 206493 толгой малыг угаалгад, 377 хороо бууцыг ариутган халдваргүйжүүлээ.

Нийгмийн ажилтан:

ГБХЗХГ-с Бүх хайраа гэр бүлдээ цахим чуулга уулзалт зохион байгуулж 5 гэр бүл оролцсон. Сумаас 1 гэр бүлийг шилдэг гэр бүлээр сонгож гарын бэлэг дурсгалын зүйл гардуулсан.

Залуусын сарын аян зохион байгуулж 120 гаруй тамирчид оролцсон.

Газрын харилцаа

45 иргэнд газрын мэдээлэл болон хороо бууцны мэдээлэл болон газрын төлбөрийн мэдээлэл өгсөн. Манлай сумын бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцсан сургуулийн засвар 75 хувьтай, цэвэр бохирын шугамын ажил 95 хувьтай, засмал замын ажил 80 хувьтай, шинэ эрүүл мэндийн төв 5% сургуулийн заалны шал 80% үйл ажиллагаа нь явагдаж байна. Нөхөн бүртгэлийн ажил хийгдэж 18 ship file үүсгэсэн байна. 5 айлын хэмжилт хийсэн. Газрын 70 газрын төлбөрийг нэхэмжлэл үүсгэсэн

Байгаль орчин

Өгөөмөр багийн нутаг дахь хөөврийн булагийн мал шигддэг хэсгийг хашсан. Нийт 300м3 газыг хашсан.

Хогийн цэгийн 500м2 орчим газрын хогийг хусаж түрсэн.

Халамж

Нийгмийн халамжийн тэтгэврийн 49 иргэнд 14025600 төгрөг, НМТэтгэмж 55 иргэн 7155080 төгрөг, ХБИргэний хөнгөлөлт 1 иргэн 20000 төгрөг, 195-н Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж 10303260 төгрөг, 1-н Алдарт цолтон ахмад настанд үзүүлсэн мөнгөн тусламжийн 150000 төгрөг тус тус олголтын жагсаалтыг үүсгэсэн ХХҮГазарт хүргүүлж .хүнсний талонд 4 өрх хамруулаа .

Хөдөө аж ахуй тасаг:

Жаргалант багт отроор ирсэн Дундговь аймгийн Хулд Дэлгэрхангай сумдын нийт 5 өрхийг нутаг дэвсгэр чөлөөлөх тухай. Ханхонгор Мандал- Овоо сумдын 7 өрхийг өвөлжөө хаваржаагаа эрт олж бэлдэх тухай асуудлаар үүрэг чиглэл зохицуулалт хийж ажилласан .

Сум хөгжүүлэх сангийн програмыг ашиглалтад оруулж 2018-2020 оны 11 төслийн мэдээллийг програмд нөхөж оруулсан.

Цэцэрлэг:

09-р сарын 01нд хичээлийн жилийн нээлтийг онлайн аар зохион байгуулсан. Тойргийн 2-5 насны 255 хүүхдээс 3-5 насны 132 хүүхдийг 6 бүлэгт хамруулсан.

Сургалт үйл ажиллагаа эхлэхээс өмнө 20 багш, ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 100% хамруулсан.

Анги танхимын цэвэрлэгээ үйлчилгээ ариутгал халдваргүйжүүлэлтийг өөрсдийн боломж бололцоогоор хийсэн. Мөн сумын ЭМТ-өөс ариутгал 2020-09-27нд хийгдсэн.

Мэргэжлийн байгууллагаар ундны усны шинжилгээ хийгдсэн.

2020.09.21нд нэмэлт элсэлт авах болж 2 настай 30 хүүхэд бүртгэгдэж. Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулаад хүлээж авна.

Өглөө оройд багш ажилчид ,сурагчид эцэг эхийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлж тэмдэглэл хөтөлж ариутгал халдваргүйдлийн дэглэмийг сахиж ажиллаж байна.

Эрүүл мэндийн төв

Сургуулийн 320 хүүхдийг цусны бүлэг тодорхойлсон. Мөн цэцэрлэгийн 98 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан.

ЕБС

2020-2021 оны хичээлийн жилд нийт багш ажилчид 38. нийт хүүхдийн тоо 382, 1-р ангид 59 хүүхэд элсэн орсон.

Судлагдахуун тус бүрээр өнгөрсөн хичээлийн жилийн агуулгаар оношилгоо авч анализ хийж дүгнэлт гарган ажиллаа. Нийт 18 судлагдахуунаар 2-9-р ангийн 323 суралцагч хамрагдлаа. Судлагдахууны гүйцэтгэлийн дундаж хувь 24,7%-тай байна.

2020 оны 08 сарын 26-29-ний хооронд удирдах ажилтны сургалт, багш нарын бага хуралд захирал, сургалтын менежер нар, 9 сарын 16-19-нд хөгжмийн багш М.Энхбаатар 3 хоногийн сургалтанд тус тус хамрагдав.

Гадаа талбайд зай барих тэмдэг, орох гарах тэмдэг, ОО хаалга бүрт гар ариутгагч байрлуулан, 13 халуун хэмжигчийг анги танхим, дотуур байранд авч өглөө.

16 ангийн ариун цэвэр, эрүүл мэндийн булан, анхан шатны тусламж үзүүлэх хэрэглэлд дотоод хяналт хийгдэв.

Дөрөв. Багт хийгдсэн ажлууд: Далай багийн төвийн барилга шинээр баригдаж ашиглалтад хүлээлгэн өгсөн .

4 багийн хүний эмч нар “ДЭМБ”-ээс санхүүжүүлсэн мөнгөн дэмжлэгээр айл өрхүүдээрээ гэрийн эргэлтийг сар бүр хийж байна. Энэ сард зорилтот бүлгийн 18 өрхөд гэрийн эргэлт хийсэн байна..

Тулгамдаж буй ажил: 15-р цэцэрлэгт: Онцгой нөхцөл байдлын үед ажиллахад цэцэрлэг бүр тусгаарлах өрөөтэй байх шаардлага тавьсан. 1 ангийг суллаж бэлтгэсэн боловч дотор байх багаж хэрэгсэл/ хантааз, халууны шил, маск, бээлий, санитол / шаардлагатай байгаа

МАНДАЛ-ОВОО

Нэг .Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр:

1. Сумын ИТХ-н болон Тэргүүлэгчдийн тогтоол 0.
2. Сумын Засаг даргын захирамж 5
3. Тамгын газрын даргын тушаал 1.

Хоёр. Хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт:

1. Засаг даргын Тамгын газрын дотоодын шуурхай хурал 2 удаа, байгууллагын дарга эрхлэгч нарын хурлыг 1 удаа зохион байгуулав.

2. Хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлууд:

-Чанарын менежментийн тогтолцооцооны олон улсын стандарт ISO 9001 хэрэгжүүлэх тухай

-Шинэ удирдлагын ордны утас интернетийн сүлжээг оруулах тухай

-сонгуулийн хэсгийн хороог байгуулах тухай

-ерөнхий боловсролын сургуулийн захирлын Албан тушаалын тодорхойлолт боловсруулж батлах тухай

-Соёлын төвийн шинэ барилга барих тендерт шалгарсан Асуд констракшн ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай

-Дүйцүүлэх албаны иргэдийг сургалтад хамруулах тухай

-Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн квотын хөрөнгөөр хэрэгжсэн төслүүдийн зураг авалт хийх тухай

- Чанарын менежментийн тогтолцооцооны олон улсын стандарт ISO 9001 сургалтад хамрагдах тухай

-Оторчдыг эргэх, төрийн үйлчилгээ үзүүлэх тухай

-“Бүх хайраа гэр бүлдээ” чуулганыг зохион байгуулах тухай

- Цэрэг татлагын арга хэмжээг зохион байгуулах, цэргийн зарлан дуудах хуудас тараах тухай
- Төрийн үйлчилгээний жагсаалт гаргах тухай
- Сумын ИТХ-д нэр дэвшигчдийг батлах тухай
- Хандивын аян өрнүүлэх тухай
- “Удмаа мэдэж, судраа цуглуулья” ургийн бичгийн үзэсгэлэнд оролцох тухай

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

1. Чанарын менежментийн тогтолцоолцооны олон улсын стандарт ISO 9001 хэрэгжүүлэхээр Монсертф ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.
2. Шинэ удирдлагын ордны утас интернетийн сүлжээг оруулж сумын Засаг даргын Тамгын газрын конторын шинэ барилга ашиглалтад орж иргэдэд 1 цэгээс төрийн үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн
3. Сумын ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах 3 Хэсгийн хороог байгуулж нийтэд мэдээлэв.
4. -ерөнхий боловсролын сургуулийн захирлын Албан тушаалын тодорхойлолт боловсруулж батлан сул орон тооны захиалгыг хүргүүлэв.
5. Соёлын төвийн шинэ барилга барих тендерт шалгарсан “Асуд констракшн” ХХК-д гэрээ байгуулах эрх олгож гэрээг байгуулав.
6. Дүйцүүлэх албаны 4, нэгдүгээр зэргийн 1 бэлтгэл үүрэгтнийг сургалтад бүрэн хамруулав.
7. Говийн оюу ХДС-н квотын хөрөнгөөр 2019-2020 онд хэрэгжсэн төслүүдийн зураг авалт хийв.
8. Отор нүүдэл хийж байгаа сумын малчдаа эргэх, тэдний санал хүсэлтийг сонсох ажлыг сумын ИТХ-ын дарга, сумын Засаг даргаар ахлуулсан ажлын 2 хэсэг зохион байгуулж, төрийн үйлчилгээг үзүүлэв.
9. “Бүх хайраа гэр бүлдээ” чуулганыг зохион байгуулж, 5 гэр бүлийг орлцуулав. Ахмад 1 гэр бүлийг аймгийн Засаг даргын шагналаар шагнаж, бусад гэр бүлийг гарын бэлгээр урамшуулж, санал хүсэлтийг нь сонсов.
10. Цэрэг татлагын арга хэмжээний цэргийн зарлан дуудах хуудсыг тараах ажлыг зохион байгуулж, нийт хамрагдах иргэдийн 40 хувьд зарыг биечлэн хүргээд байна.
11. иргэд байгууллагад үзүүлэх Төрийн үйлчилгээний жагсаалт гаргаж, сумын ЗДТГ-ын үйлчилгээний журмыг боловсруулах ажлыг зохион байгууллаа.
12. Турк улсад хүндээр өвчилсөн тус сумын уугуул иргэн Н.Өлзийцэцэгт туслах Хандивын аян өрнүүлж нийт 2,6 сая төгрөгийн хандив цуглуулж хүргэв.
13. “Удмаа мэдэж, судраа цуглуулья” ургийн бичгийн үзэсгэлэнд 3 иргэн амжилттай оролцож, Ё.Долгормаагийн бүтээл “Ураг төрлийн хэлхээ сайтай угийн бичиг”-ээр шалгарав.
14. “Соёлын ажилтны өдөр”-ийг Цогт-Овоо сумтай хамтран тэмдэглэж, нийт 23 соёлын салбарын ажилтнууд хамрагдав.
15. Ерөнхий боловсролын сургуулийн залуу багш нарын сургалтад 6 багш хамрагдав.
16. Аймгийн орон нутгийн төсвийн 40 сая төгрөгний хөрөнгөөр сургуулийн бүх анги танхимыг модон ширээ сандалаар хангав.

Дөрөв: Багт хийгдсэн ажлууд:

1. Тус суманд гантай байгаагаас 286 малчин өрхийн 200 гаруй мянган мал Өвөрхангай аймгийн Төгрөг, Баянгол, Дундговь аймгийн Луус, Дэлгэрцогт, Дэрэн, өөрийн аймгийн Манлай, Цогт-цэций, Цогт-Овоо, Ханхонгор, Номгон, Хүрмэн, Баян-Овоо зэрэг сумдын нутагт оторлож байгаа бөгөөд Сумын засаг дарга, багийн Засаг дарга нар оторчдоо эргэж төрийн болон эмнэлгийн үйлчилгээг хүргэв.
2. Гурван багийн нийт 137220 бог малыг угаалгад хамруулав.

ЦОГТ-ОВОО

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр

Энэ сард сумын ИТХурлаас тогтоол гараагүй . Засаг даргын А захирамж 2, Тамгын газрын даргын А тушаал 4, Б тушаал 2 тус тус гарсан байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал

“ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛ- ЁС ЗҮЙН ХАНДЛАГА” ёс зүйн зөвлөлийн 3 өдрийн онлайн сургалтанд давхардсан тоогоор 47 төрийн албан хаагч хамрагдсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 жилийн хэрэгжилтийн тайланг сэтгүүл бэлтгэж 450 ширхэгийг хэвлүүлж сумын нийт иргэдэд хүргэж ажилласан.

- 09 сарын 04-ны өдөр Угийн бичгийн үзэсгэлэнг зохион байгуулж шилдэг байгууллага 1, иргэн 3-ыг тус тус шалгаруулж Өмнөговь аймагт зохион байгуулсан Угийн бичгийн үзэсгэлэнд оролцууллаа

- 2020 оны Үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу "Өрх, гэр бүлийн хөгжлийн жилийн" хүрээнд сумын нийт хүн амын дунд өвчлөлийн хувь өндөр байгаа амны хөндийн өвчлөлийг бууруулах зорилгоор ОНХСангаас 9,0 сая төгрөг төсөвлөгдсөн бөгөөд сумын Засаг даргын урилгаар Улаанбаатар хотын “БЭР ЦЭЦЭГ ДЕНТ” шүдний эмнэлгийн шүд, эрүү нүүрний их эмч, тус сумын уугуул иргэн Б.Түмэн-Өлзий, шүдний сувилагч Х. Батцэцэг нар ирж 2020 оны 10 хоногийн хугацаанд ажилласан бөгөөд шүдний үзлэг, эмчилгээнд цэцэрлэгийн насны 33 хүүхэд, сургуулийн насны 88 хүүхэд, 18-60 насны 156 нийт 277 иргэн тус тус хамрагдаж эмчилгээ хийлгэлээ.

Мөн 43 иргэнд зохих төлбөртэй хиймэл шүд хийж үйлчилгээ үзүүлсэн бөгөөд нийт 277 иргэнд 17,6 сая төгрөгний эмчилгээг үнэ төлбөргүй хийсэн байна. Үүнээс ОНХСангаас 9,0 сая төгрөг "БЭР ЦЭЦЭГ ДЕНТ" эмнэлгийн зүгээс сумын иргэдэд 8,6 төгрөгний шүдний эмчилгээг тус тус үнэ төлбөргүй хийгдлээ.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил, арга хэмжээ

Залуучуудын хөгжлийн сарын аяны нээлтийг зохион байгуулж ажилласан. Нээлтэнд 21 залуу оролцож өөрсдийн санал бодлыг орон нутгийн удирдлагад хүргэх үйл ажиллагааг зохион байгууллаа.

Тав. Багт зохион байгуулагдсан ажлууд

Багийн Иргэдийн Нийтийн хурлын товыг 2020 оны 09 сарын 21,22,23-ны өдрүүдэд багийн төв болон сумын төвд хийхээр төлөвлөн хурлын товыг иргэдэд утас болон цахимаар хүргэж байна.

ГУРВАН ТЭС

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

ЗДТГ: Шивээхүрэн хилийн боомтоор нүүрс тээвэрлэлт явуулж эхэлсэнтэй холбогдуулан нүүрсний 4 уурхай, нүүрс тээврийн 37 ХХК үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Шивээхүрэн хилийн боомт болон Морин загийн постонд 2 байгууллагын 13 албан хаагчид ажиллаж байна. Өдөртөө 300, 350 нүүрс тээврийн авто машин хилээр тээвэрлэлт хийж байна.

Сумын Засаг дарга 7 хоног бүрийн 3 өдөр Шивээхүрэн хилийн боомт Морин загийн постонд ажиллаж байна. мөн сумын онцгой комиссын гишүүд болон төрийн албан хаагчид хувиарын дагуу ажиллаж байна.

Хоёр: Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан ажил

Гурав: Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

- Сумын шуурхай жижүүрийг 24 цагаар гарган ажиллаж мэдээг 10, 12, 17, 19 цагт өгч байна.

- Сумын төвийн 2 км хатуу хучилттай авто замын ажил явагдаж байна.

- Өсөх зоос ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд 90 сая төгрөгний хөрөнгөөр спорт заалын засварын ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.

- Алдарт эхийн 1 дугаар одонг 1 ээж, 2 дугаар одонг 10 ээжид гардуулан өгсөн.

- Хичээлийн шинэ жил эхэлж Засаг даргын Тамгын газраас сургуулийн 18 хүүхдэд хичээлийн хэрэглэл гардуулан өгсөн.

- Элсэлтийн ерөнхий шалгалтаар өндөр оноо авсан 4 сурагч, амжилттай бэлдүүлсэн 3 багшид талархал мөнгө урамшуулал олгоо .
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хогийн цэг байгуулсан.

ХҮРМЭН

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

2020 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 18 захирамж, 4 тушаал гарсан байна.

Үүнд: Захирамж

- Хөрөнгө зарцуулах тухай /4 захирамж/
- Ажлын хэсэг байгуулах тухай /4 захирамж/
- Ажлын байрны тодорхойлолт батлах тухай
- Сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх тухай /4 оюутанд/
- Иргэнд газар эзэмшүүлэх тухай /2 захирамж/
- Соёлын төвийн орон тооны дээд хязгаар батлах тухай
- Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай
- Цолны мялаалга наадамд дэмжлэг үзүүлэх тухай

Тушаал:

- Хөрөнгө зарцуулах тухай
- Ажил хүлээн авах комисс байгуулах тухай
- Бүтэц орон тоо цалингийн сан батлах тухай тушаалд өөрчлөлт оруулах
- Бүх хайраа гэр бүлдээ арга хэмжээний зардал гаргах тухай

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

- ❖ Эрүүл мэндийн төв
- “Та хоцроогүй биз” аяны 2-р шатны үзлэг 2020.09.15-2020.09.17-ны хооронд ХСҮТ-ийн Дотор, Мэдрэл, БЗХӨ, лабортори, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, элэгний эмч нар ирж Хүрмэн сумын эрүүл мэндийн төвд 3 хоног ажилласан.
- 2020.09.15-2020.09.16-ны 2 өдрийн байдлаар нийт 134 хүн үзүүлж, эмчилгээ зөвлөгөө авсан байна. Эхний шатлалын үзлэгийг сумын эмч нар өөрсдөө зохион байгуулж 15-аас дээш насны нийт 1023 хүн үзэх байснаас 967 хүн амыг хамруулж, 94,5%-тай ард иргэдээ хамруулсан. Үүнээс нийт 2-р шатлалд үзүүлэх 293 хүн байснаас 134-н ард иргэдийг одоогийн байдлаар үзлэгт хамрууллаа.
- ❖ Цэцэрлэг
- Өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан, эрүүл ахуй, ариун цэврийн дэглэмийг сахиж ариутгал цэвэрлэгээг тогтмол хийж байна.
- Энэ хичээлийн жилд нийт 74 хүүхэд бүртгэгдэж өдрөөр 60 хүүхэд бүртгүүлснээс одоогоор 43 хүүхэд хамрагдаж байна. Хувилбарт сургалтанд 14 хүүхэд хамрагдаж байна.
- ❖ Ерөнхий боловсролын сургууль
- 2020-2021 оны хичээлийн шинэ жилийн үйл ажиллагааг эхлүүлж, нийт 140 сурагчтай үүнээс 1-р анид 25 сурагч элсэн орж, дотуур байранд 40 сурагч амьдарч байна. Хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

- ❖ Байгаль орчин
- 2020 оны 09 дүгээр сарын 07 өдрөөс эхлэн Хүрмэн, Тулга ,Жанжин багуудын нутаг дэвсгэрт болон отрын бүс нутаг, гар аргаар алт олборлосон газруудад хяналт шалгалтыг сумын Цагдаагийн хэсэг, ЗДТГазрын холбогдох мэргэжилтэнгүүдийн хамт 4 хоног явж ажиллаа. Отроор орж ирсэн Сэврэй, Ноён, Баяндалай, Булган, Мандал-овоо, Ханхонгор зэрэг 6 сумын одоо байгаа 33 өрхийн 30500 гаруй мал отроор орж ирсэн бөгөөд тэдгээр өрхийн иргэдтэй уулзаж судалгааг авч ,хог хягдал, үхсэн малын сэг зэмийг устган булшлах талаар зөвлөмж зөвлөгөө өглөө. Жанжин багийн нутаг Хашаатын хэц, Чавганцын хард 2020 оны 08 дугаар сарын 30, 31, 09 дүгээр 01-ний өдрүүдэд алт олборлосон тухай мэдээллийн дагуу газар дээр нь шалгаж баримтжуулсан.
- ❖ Хөдөлмөр, нийгмийн халамж
- 2020 оны 09 дугаар сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 28 иргэний 8,242,400 төгрөг, тэтгэмжид 36 иргэнд 5,057,580 төгрөг, 1 алдар цолтонд 150000 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнд харилцаа холбооны зардал 20000 төгрөг, жирэмсэн 17 эхэд 595160 төгрөг, цалинтай эхийн тэтгэмжид 72 эхэд 3,523,330 төгрөгийн олголтын жагсаалтыг гарган аймгийн ХХҮГазарт хүргүүлээ.
- Нийгмийн халамжийн нэгдсэн систем нь төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй үзүүлэх зорилготой жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, 0-18 хүртэлх насны 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж, насны хишигийн тэтгэмж зэрэг үйлчилгээнүүдийг www.ehalamj.mn системд цахимаар бүртгүүлэх боломжтой болсныг иргэд хөдөлмөрчдөд мэдээлэл хүргэн ажиллаа.

ХАНБОГД

1.ИТХурлын тогтоол, Засаг даргын захирамж, албан тоот

Сумын ИТХурлын төлөөлөгчдын хурлын тогтоол-0, ИТХурлын тэргүүлэгчдийн хурлын тогтоол-2 явуулсан бичиг 3 ИТХ-д ирсэн бичиг 0 Сумын Засаг даргын захирамж-20 тушаал 5, явсан бичиг 62, ирсэн бичиг ИОфиссоор 45, өргөдөл 0, бичиг тус тус гарсан байна.

Ханбогд сумын Засаг даргын тамгын газар:

- Төрийн албан хаагчдад ёс зүйн зөвөлгөөн онлайнаар зохион байгуулагдаж Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчид, төрийн үйлчилгээний албан хаагчид 100% хамрагдлаа.
- Өрх гэр бүлийг дэмжих жил 2020” Гэр бүлийн чуулган зохион байгуулж сум орон нутагтаа салбар салбартаа алдаршиж, өрх гэр бүлийн соёл, үнэт зүйлээр бусдад үлгэрлэн манлайлсан Шилдэг 5 гэр бүл тодруулан мөн шилдэгийн шилдэг гэр бүлийг шалгарлуулан урамшууллаа .
- 2020 оны 09 дугаар сарын 08-ны өдөр хүүхэд хамгааллын хамтарсан баг 17 хүний бүрэлдэхүүнтэй хуралдав.

21 дүгээр цэцэрлэг

- 2020-2021 оны хичээлийн жилийн 2 настангуудыг 9-р сарын 17-ны өдөр бүртгэж нийт 32 хүүхдийг бүртгэж анги бүлэгт хувиарллаа.

22-р цэцэрлэг

- Ёс зүйн хорооны онлайн хуралд эрхлэгч, арга зүйч, 1 багш , ажлын байран дээрхи сургалтад 20 багш ажилчид хамрагдсан.
- Хамран сургах тойргийн хүүхдүүдийг бүртгэж.Нийт 167 хүүхдийг 7 бүлэгт хамруулж. Бүлгийн багш ажилчид хүүхдүүдийг үзлэг шинжилгээнд 100 % хамрууллаа
- Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “School police” эргүүлийг эцэг эхчүүдийн оролцоогоор хэрэгжүүлж байна.
- Нийт 29 багш ажилчид бүгд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан.

29-р цэцэрлэг

- 2020 оны 08 сарын 25-26ны өдрүүдэд тойргийн 3-5 настай 226 хүүхдийг бүртгэн анги бүлэгт хувиарлаж сургалт хүмүүжлийн ажлаа эхлүүлсэн

Ерөнхий боловсролын 1-р сургууль

- Сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Багш, ажилчдын нэгдсэн хурлыг 2 удаа, Заах аргын нэгдлүүд шуурхай хурал 2 удаа хийлээ.
- 2020-2021 оны хичээлийн жилд нийт 34 багш, 12 ажилтан ажиллаж 780 сурагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна Үүнээс нэг дүгээр ангид 116 сурагч элсэн орлоо.

Сум дундын эмнэлэг

- Шинэ коронавирусын өвчний талаар тухайн цаг үеийн мэдээлэл, сурталчилгааг Ханбогд сум дундын эмнэлгийн page хуудсанд өдөр бүр тогтмол байршуулж байна.
- Коронавирустай холбоотойгоор цаг үеийн мэдээнүүд, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, тарваган тахал болон гэдэсний халдварт өвчнөөс сэргийлэх зэрэг мэдээллүүдийг тогтмол эмнэлэг page хуудсаар дамжуулан ард иргэдэд хүргэж байна.
- Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газарт өдөр бүр томуугийн мэдээг 7-8 цагийн хооронд мэдээлэлж байна.
- Коронавирустай холбоотойгоор цаг үеийн мэдээнүүд, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, тарваган тахлаас сэргийлэх зэрэг мэдээллүүдийг тогтмол эмнэлэг page хуудсаар дамжуулан ард иргэдэд хүргэж байна.
- эмчлүүлэгчийн тоо, алс ойрын дуудлага зэрэг мэдээг тогтмол өгч байна.
- Эмнэлгийн ажилчид хамтран эмнэлгийн дотоод хүлээн авах, тасгууд, өрөөнүүдийг засварлах болон гадаа их цэвэрлэгээг зохион байгуулсан.

Эрүүл Ханбогд аяны хүрээнд

- Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг
- Хавдар Судлалын Үндэсний Төв
- Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв
- Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн их эмч, мэргэжилтнүүд ирж нийт 569 хүнд Чих хамар хоолой, Уушиг, Бөөр, Хоол боловсруулах эрхтэн, Зүрх судас, Дотоод шүүрэл, Урологи, проктологи, Мэдрэл, Нүд хараа зүй, Дүрс оношлогоо, Хавдар, Гэмтэлийн эмч нар тус тус нарийн мэргэжлийн үзлэг оношлогоо хийсэн.
- Төрийн албан хаагчын ёс зүйн зөвөлгөөнд байгууллагаас төлөөл хамруулж, хамрагдсан төлөөлүүд нийт ажилчиддаа сургалт зохион байгуулсан.

- СДЭ, Залуучууд хөгжлийн төв, Zumba fitness club, Оюуны Өргөө ТББ хамтран “Үнэгүй фитнэсс Ханбогд” аяныг 8 сарын 28-наас эхлэн өглөө бүр 6 цагаас “Галба талбай”-д зохион байгуулж байна. Нийт 25-30 хүн тогтмол хамрагдаж байна.
- Ханбогд Сум Дундын эмнэлэгийн хамт олон магадлан итгэмжлэх шалганд байгууллагаараа амжилттай оролцсон.
- Цагаан хад суурьшлын бүсэд тусгаарлалтанд байгаа жолооч нарыг COVID-19-ийн түргэвчилсэн тестээр тусгаарлалтаас гарах хугацаа бүрт нь оношилж байгаа. Тусгаарлалтанд байгаа жолооч нарт багийн бага эмч О.Ариунаа хяналт тавин ажиллаж шаардлагатай тохиолдолд COVID-19-ийн соригыг ХӨСҮТ-т хүргүүлэх ажлыг гүйцэтгэсэн.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

- Гадаадын иргэн, харьяатын газрыг тоног төхөөрөмжөөр хангах, Цагдаагийн газрын байнгын постонд камер суурилуулах, Автозамын шаардлагатай цэгүүдэд засвар үйлчилгээ хийж, тоног төхөөрөмж суурилуулах ажлын техникийн нөхцөлийг батлуулан Орон нутгийн өмчийн газраар тендер зарлуулсан.
- Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн хамтран зохион байгуулсан төрийн байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийн нэгдсэн зөвлөгөөнд албан хаагчийг хамруулсан
- Удирдлагын академиас зохион байгуулсан “Гүйцэтгэлийн үнэлгээ” сэдэвт сургалтад албан хаагчийг хамруулсан
- Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүн амын сангаас Өмнөговь аймагт хэрэгжүүлж байгаа нэгдсэн хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилт, 2021 оны хийх ажлын төлөвлөгөө хэлэлцэх техникийн ажлын хэсгийн хуралд албан хаагчийг хамруулан 2021 оны төсөвт дундаж хурд хэмжих 2 ширхэг камер суурилуулах санхүүжилтийг суулгасан.
- Хууль, эрх зүйн хэлтсийн дарга нь аймгийн Сонгуулийн хороонд, мэргэжилтнүүд сонгуулийн хэсгийн хороонд тус тус томилогдон ажиллаж байна
- Аймгийн Засаг даргын хариуцагчаар татагдсан маргаануудын давж заалдах шатны шүүх хуралд 3 удаа явж оролцсон.
- Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын хариуцагчаар татагдсан маргааны анхан шатны шүүх хуралд 5 удаа оролцсон.
- Төрийн архивын тасаг нь 137 иргэнд архивын лавлагаа, 535 иргэнд архивын баримтын хуулбар олгосон.
- 122 иргэн, 18 хуулийн этгээдэд хүчин төгөлдөр хууль тогтоомжийн лавлагаагаар үйлчилсэн.
- Хэлтсийн чиг үүрэгт хамаарах өдөр тутмын ажил, удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг хэрэгжилтийг тухай бүр хангаж ажиллаж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ

Газрын харилцаа, хот байгуулалт

- Аймгийн Засаг даргын захирамжаар 17 иргэний газрын өмчлөлтэй холбоотой шийдвэр гаргасан.
- Аймгийн Засаг даргын захирамжаар 11 иргэн, хуулийн этгээдэд газрыг шинээр буюу шинэчлэн эзэмшүүлсэн.

- Дахин төлөвлөлтийн 2, 3-р орон сууц чиглэлийн автозам, зогсоолын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг зарлав.
- Цогтцэций сумын төвийн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн зураг төсөл боловсруулах ажлын сонгон шалгаруулалтыг зарлав.
- Өмнөговь аймгийн “Цэнгэлдэх хүрээлэнгийн тартан зам”-ын зураг төсөл, төсөв боловсруулах гэрээ байгуулж ажлыг эхлүүлэв.
- Сэврэй, Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн зураг төсөл боловсруулах ажлын гэрээ байгуулж ажлыг эхлүүлэв.
- Ханбогд сумын Цагаан хадны суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөний дагуу иргэдэд өмчлүүлсэн газарт цахилгааны шугам сүлжээ татах шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг зарлав.

Хүнс, хөдөө аж ахуй, үйлвэрлэл

- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 419, 2020 оны 19 дүгээр тогтоол, орон нутгийн намаржилт, отор нүүдлийн зохион байгуулалт, өвөлжилт, хаваржилтын төлөв байдалтай холбогдуулан сумдын удирдлагуудтай “Өвлийг өнөтэй давъя” уулзалт зохион байгуулж орон нутгийн мал аж ахуйн намарчилтын байдал, отор нүүдэл, тулгамдсан асуудлаар хэлэлцэж “Отор нүүдлийг хамтран зохион байгуулах хамтран ажиллах гэрээ” байгууллаа.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, аймгийн Засаг даргын тамгын газрын гурвалсан гэрээний дагуу орон нутгийн төсвөөс Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжүүлэх санд байршуулсан эх үүсвэрээс санхүүжүүлэх болон Улсын төсвийн эх үүсвэр, хөрөнгийн эх үүсвэр үлдсэн тохиолдолд санхүүжүүлэх төслүүдийг аймгийн Засаг даргын 2020 оны А/959 дугаар захирамжаар баталгаажуулж хүргүүлсэн.
- Орон нутгийн газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх зорилгоор “Говийн бүсэд таримлын аж ахуй хөгжүүлэх боломж” талбайн болон танхимын үзүүлэх сургалтын арга хэмжээг ХХААХҮЯ, БОАЖЯ, ХААИС-тай хамтран зохион байгуулж Хүлэмжийн цогцолборт байгуулагдсан Сургалтын төвийн барилгын нээлтийг хийлээ.
- Орон нутгийн намаржилт хүндрэлтэй отор нүүдэл ихтэй байгаатай холбогдуулан бэлчээрийн нөөцтэй боловч усан хангамж хүрэлцээгүй газарт 4 инженерийн хийцтэй худаг шинээр гаргах ажлыг нэмэлт гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна.
- Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 30 инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, 30 худаг сэргээн засварлаж ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан ба ажлын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна.
- “Хүлэмжийн цогцолборын сургалтын байрыг тохижуулах” ажлын гүйцэтгэлийг хүлээн авах комиссыг томилж ажиллуулан гэрээт ажлын гүйцэтгэлээр нийлүүлсэн тавилга эд хогшлыг хүлээн авч ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөв.
- Мал угаалга, хороо бууцны ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан ба тус ажлын гүйцэтгэл 75 хувьтай үргэлжлэн хийгдэж байна.

Байгаль орчин аялал жуулчлал

- 15 сумын нутаг дэвсгэрт 15 булаг шандны эхийг хашиж хамгаалах ажлыг 08-09 сард хэрэгжүүлж байна. Тус ажлыг баруун зүүн бүсийн сумдаар бүсчилэн тендерт шалгарсан 2 ААН-ээр гүйцэтгүүлж ажил 90 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.
- Баянзагийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тохижилт бүтээн байгуулалт” багц-1,2,3 ажлыг 05-09 сард бүрэн гүйцэтгүүлж Улсын комисс ажиллан ашиглалтад оруулав.

- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос Монгол орон даяар Хоггүй цэвэрхэн Монгол аяны 05 сараас зохион байгуулж эхэлсэн. Тус аяны хүрээнд манай аймагт эрх шилжүүлсэн 50,0 сая төгрөгөөр Даланзадгад сумыг төвийн төвлөрсөн хог хаягдлын цэгийг хашаажуулах талбайн хэмжээг багасгаж, орчны бохирдлыг буулах ажлыг эхлүүлээд байна. Уг ажлын тендерт шалгарсан Эрхэм говь ХХК-тай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулаад байна.
- Ан амьтны усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор нар салхины энергээр ажилладаг гүн өрмийн худгийг Баяндалай, Цогт-Овоо сумдад гаргах ажлыг Ундрага-Өмнөговь ХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж 09 сард улсын комисс ажиллан ашиглалтад бүрэн оруулаад байна.
- Манлай суманд нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайг байгуулж ашиглалтад бүрэн оруулав.

Уул уурхай, эрчим хүч

- “Аймгийн төвийн гэр хорооллын дулаан, цэвэр, бохир усны шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил” багц-1, багц-2, багц-3, багц-4 ажлын гэрээ байгуулав.
- Цогтцэций сумын төвийн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажлын улсын комисс ажиллуулж, байнгын ашиглалтад оруулах комисс томилов.
- Даланзадгад сумын төвийн гадна гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийг нэмэгдүүлэх ажлын гэрээ байгуулах ажлын тендер зарласан.
- Даланзадгад сумын орон сууцны гадна, дотор шугам сүлжээг дулаан хангамжийг засварлах ажлын явцад хяналт хийв
- “Даланзадгадын дулаан хангамжийн газрыг шаардлагатай эх үүсвэр машин механизмаар хангах” ажлын техник, механизмыг комиссын актаар хүлээн авч ажиллагаанд орууллаа.
- Төв суурин газрын 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажил хангах 9-р сарын тайланг нэгтгэж, Эрчим хүчний сайдад мэдээлэл хүргүүлэв.

НИЙГМИЙН БОДЛОГО

Эрүүл мэнд

- Эмэгтэйчүүд залуучуудын эрүүл мэндийн дэмжих нэгдсэн хөтөлбөрийн техникийн ажлын хэсгийн хурлыг Хүн амын сан, Хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулж, 2021 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн удирдах хорооны хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн удирдлагын баг, эмч мэргэжилтнүүдтэй 2 удаагын уулзалт зохион байгуулж ажиллаа. Уулзалтын үр дүнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн түргэн тусламжийн автомашины засвар үйлчилгээнд шаардлагатай төсвийг шийдвэрлэсэн. Мөн эмнэлгийн 100 оронд нэн шаардлагатай зөөлөн эдлэлийн төсвийг шийдвэрлэсэн.
- Орон нутгийн төсвийн санхүүжилтээр Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газрын албан хаагчид, сургууль цэцэрлэгийн багш нар, зам тээврийн ажилчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг томуугийн сайн дурын дархлаажуулалтад хамруулах арга хэмжээг зохион байгуулж байна. Томуугын дархлаажуулалтад нийт 1540 хүнийг хамруулахаар төлөвлөн вакциныг татан авах арга хэмжээг зохион байгуулж байна.
- Элэгний хавдрыг бууруулах, элэгний в вирусийн өвчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг элэгний хавдрын эрт илрүүлэг

шинжилгээнд хамруулан, сайн дурын дархлаажуулалтад хамруулах арга хэмжээг зохион байгуулж байна. Нийт 300 иргэнийг хамруулахаар төлөвлөн үйл ажиллагааг эхлүүлсэн.

- Аймгийн хэмжээнд шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өндөржүүлсэн бэлэн байдал хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Коронавирусийн болзошгүй эрсдэлтэй холбоотойгоор 2020 оны 09 дүгээр сар 23-ний өдрийн байдлаар 328 иргэнийг тусгаарлан ажиглаж байна.

Хөдөлмөр хамгаалал

- “Удмаа мэдэж судраа цуглуулъя” аймгийн угийн бичгийн үзэсгэлэн зохион байгуулагдаж 15 сумын 110 гаруй угийн бичээсийг олон нийтэд танилцуулсан.
- “Бүх хайраа гэр бүлдээ” аймгийн гэр бүлийн чуулганыг зохион байгуулж гэр бүлийн боловсролыг нэмэгдүүлсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд нийт 250 гаруй хүн хамрагдсан.
- Өрх, гэр бүлийн хөгжлийн жилийн хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор 24 иргэнд гэр гардууллаа.
- Өрх, гэр бүлийн хөгжлийн жилийн хүрээнд “Шилдэг гэр бүл шалгаруулах” батлагдсан удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн 15 сумын 25 шилдэг гэр бүлийг шалгаруулан Өргөмжлөл, дурсгалын зүйл гардуулсан.
- Хичээнгүй үндэс ТББ-тай хамтран “Хариуцлагатай гэр бүл” гэр бүлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.
- “Нэг өрх - нэг ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгийн иргэдийг ажлын байранд зуучлах аян зохион байгуулагдаж байна.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн улсын үзлэгийг Өмнөговь аймгийн хэмжээнд авто замын салбарт зохион байгуулсан.
- “Хөгжлийн ирээдүй-оюунлаг залуучууд” хөтөлбөрийн хүрээнд “3 үеийн уулзалт”-ыг боловсролын салбарын багш, ажилчдын дунд зохион байгуулсан. Өрх, гэр бүлийн хөгжлийн жилийн хүрээнд 3 гэр бүлийн хуримын ёслолын үйл ажиллагааг зохион байгуулсан.
- “Залуучуудын хөгжлийн сарын аян”-ыг зохион байгуулж 15 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж аймгийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл хуралдсан.
- Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд “Хөгжлийн ирээдүй оюунлаг залуучууд” дэд хөтөлбөр, “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль” болон залуучуудад чиглэсэн мэдээ мэдээллийг Өмнөговь аймгийн Мобиком, Юнителийн хэрэглэгч 15-34 насны залуучуудад масс мессэжээр 4 удаагийн давтамжтай хүргэсэн.

Соёл, спорт

- Өмнөговь аймгийн ард иргэдэд “Соёлын цаг” аяны хүрээнд соёл, урлагийн үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчилж, “Номын баярын өдөр”- тэй хамтатган 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр амжилттай зохион байгуулсан. \
- Өмнөговь аймгийн Ханхонгор сумын харьяат Цэдэнбазарын Одбаярын харцага цолны мялаалга наадмыг 2020 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж, хүндэтгэл үзүүлсэн

Боловсрол

- Цогтцэций суманд улсын төсвийн хөрөнгөөр 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг барьж, ашиглалтад орууллаа. Тус цэцэрлэгийг 31 дүгээр цэцэрлэг нэртэйгээр байгуулж, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.
- Багш нарын бага хурлыг зохион байгуулж, 2020-2021 оны хичээлийн жилийн зорилго, зорилтоо хэлэлцэн батлав. 2020 онд Элсэлтийн ерөнхий шалгалтаар улсад 2 дугаар байрт шалгарсантай холбогдуулан багш, удирдах ажилтнуудыг шагнаж урамшууллаа. Нийт 92 хүний 60.0 сая төгрөгөөр шагнав.
- Элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан төгсөгчийг 2.0 сая төгрөгөөр урамшуулж, сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэв.
- Боловсролыг дэмжих жилийн хүрээнд хийсэн ажлын талаар 10 цуврал нэвтрүүлгийг Өлзий ТВ-ээр хийлгэж, олны хүртээл болгов.
- Даланзадгад сумын 5 дугаар сургууль, Гурвантэс сумын сургуульд Экологийн боловсрол олгох сурагчийн хөгжлийг дэмжих төвийг Монголын Эклоги төв, Европын холбооны санхүүжилтээр байгуулж, хүүхэд хөгжих, экологийн боловсрол олгох боломжийг бүрдүүлэв.

САНХҮҮ, ТӨРИЙН САН

- Аймаг, сумдын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2020 оны эхний 8 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч орлого, зарлага эдийн засгийн ангилал тус бүрээр Фрийбаланс программ дахь төсвийн гүйцэтгэлтэй тулган баталгаажуулж, Сангийн яамны Төрийн сангийн газарт татууллаа.
- Аймгийн төрийн сангийн харъяа нийт 43 төсөвт байгууллагын 2020 оны эхний 8 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулсан
- Орон нутгийн төсвийн орлогын 2020 оны эхний 8-р сарын мэдээг аймгийн Татварын хэлтэстэй тооцоо нийлж, баталгаажуулсан.
- Орон нутгийн төсвийн байгууллагуудын 2020 оны эхний 8 сарын өр авлагын мэдээг хүлээн авч, нэгтгэн Сангийн яаманд илгээлээ.
- “Төсөв санхүүгийн өнөөгийн байдал” мэдээллийн эмхэтгэлийг 2020 оны эхний 8 сарын байдлаар нэгтгэн хэвлэж, мэдээллийн самбар, E-оффисс болон аймгийн вэб сайтад мэдээлсэн болно.
- Сумдын санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвийн байгууллагуудын 9-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо.
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 9-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо.
- Аймгийн төрийн сангийн харъяа 43 төсвийн байгууллагын үндсэн данс болон, нэмэлт санхүүжилтийн дансны төлбөр тооцоог өдөр тутамд төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу, эдийн засгийн ангилалын дагуу хянаж, хийж гүйцэтгэн, баталгаажуулж ажиллалаа.
- Өмнөговь аймгийн нийт 15 сумаас ирүүлсэн Фрийбаланс программд бэлтгэн нийлүүлэгчийн данс нэмэх, бэлтгэн нийлүүлэгчийн мэдээллийг засварлах, Санхүү албаны дарга нарын гүйлгээ баталгаажуулаагүй орхигдуулсан эсэх, төсвийн байгууллагын орлого хаах журналын бичилт хийх, сумдын орлого хаасан эсэхэд өдөр тутам хяналт тавьж ажиллалаа.
- Төрийн сангийн фрийбаланс программд бүртгэлгүй хувь хүн болон аж ахуй нэгж байгууллагуудын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлсэн хүсэлтийн дагуу регистрийн дугаар, нэр, арилжааны банкны дансны дугаарыг төрийн сангийн фрийбаланс программд шинээр бүртгэсэн.

- Засгийн газрын 2020 оны 430 дугаар тогтоолын дагуу төрийн албаны цалингийн нэгдсэн систем (ТАЦНС)-ийг аймагтаа нэвтрүүлэх амжилттай зохион байгуулж, бүх байгууллагын цалингийн гүйлгээг хийлээ.
- ОНТХО, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн холбогдох материалын бүрдлийг хянан, гүйцэтгэлийн баталгааг холбогдох Банкнаас тодруулж, санхүүжилтийн тооцоог хийж санхүүжилтийг олгож ажилласан бөгөөд 2020 оны 09 дугаар сарын урьдчилсан байдлаар ОНХСангаас 952.8 сая төгрөг , ОНТХО-аас 8,098.5 сая төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилтийг тус тус олгоод байна. Гэрээнд тусгагдсаны дагуу барьцаа хөрөнгийг суутган байршуулж мөн холбогдох баримт материалыг үндэслэн эрх бүхий байгууллагаас ирүүлсэн зөвшөөрлийн дагуу барьцаа хөрөнгийг чөлөөлж компаниудад олгож ажилласан.
- 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлсэн 2-н ААНБ-ын санхүүгийн тайланд холбогдох материалыг үндэслэн залруулга хийсэн. Шинээр байгуулагдсан 9 компанийг бүртгэж, 13 компанийн нууц үг солих болон тайлан тушаах хуулийн хугацааг сунгаж программд оруулсан.

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБА

Мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг

- Өмнөговь аймгийн албан ёсны сайт <http://www.omnogovi.gov.mn/>, Засгийн газрын <https://www.zasag.mn/> болон гэрээт сайтууд, Өмнөговь пэйж хуудсандаа төр засгийг бодлого шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй холбоотой 29 мэдээг 9-р сард нийтэлж иргэд уншигчдад хүргэсэн байна.
- Өмнөговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны тайлан мэдээг өдөр бүр өөрийн пэйж хуудас болон гэрээт тв-ээр мэдээлсэн байна.

ИРГЭДЭЭ СОНСОХ 70530001 УТСАНД ИРСЭН САНАЛ ХҮСЭЛТИЙН ТАЙЛАН

- Иргэдээ сонсох утсанд 9-р сарын байдлаар 3 санал хүсэлт гомдол ирснээс 2 хүсэлт 1 гомдол ирсэн байна. Иргэдээс ирсэн санал хүсэлтийг холбогдох албан тушаалтанд уламжилж цаг алдалгүй шийдвэрлэж байгаа иргэнд хариу мэдээг хүргэсэн. Өдөрт дунджаар 20-25 дуудлага ирж төрийн албан хаагчийн утас болон төрийн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл авахаар холбогдож байна.

ХУРЛЫН ТАНХИМУУД:

- Сүлд танхимд: давхардсан тоогоор 700 гаруй хүн хамарсан сургалт, арга хэмжээ зохион байгуулагдсан байна.
- Соёлын танхимд: Засварын үйл ажиллагаа үргэлжилж байна.

САРЫН МЭДЭЭ НЭГТГЭСЭН.....МЭРГЭЖИЛТЭН Г.УУГАНТУЯА